

АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ, ЗОХИСТОЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НЬ

Б.МӨНХЦЭЦЭГ¹

Төрийн аудитын байгууллагын 2023 оны зорилтыг хангах төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөө, ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах нь” сэдэвт илтгэлийн уралдаанд зориулан “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, зохистой хариу арга хэмжээ авах нь” сэдвийн дагуу энэхүү судалгааны ажлыг боловсруулав.

Хураангуй: Аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, шийдвэр үйлчлүүлэгч, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, баримт нотолгоонд тулгуурласан, бодитой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой, үр өгөөжтэй байх нь нэн чухал юм. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх дээд байгууллагын хувьд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол үр дүн болох аудитын шийдвэр, зөвлөмж нь тогтоосон шаардлагад нийцэж, хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын зорилго юм. Энэхүү судалгаа нь тодорхойлох буюу дискрептив судалгааны ангилалд хамаарах бөгөөд 100 хувь батлагдсан бодит мэдээллийн санд үндэслэсэн тул судалгааг энэ ангилалд хамруулан төлөвлөж, гүйцэтгэсэн. Уг судалгааны онцлог нь баримтаар нотлогдож батлагдсан төрийн аудитын албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийг хамруулах тодорхой хязгаарлагдмал хүрээнд хийгдэж байгаа бөгөөд тоо хэмжээний хувьд их хэмжээний мэдээлэл байсан тул судалгааны эх олонлогоос түүврийг оновчтой сонгохыг эрмэлзсэн болно. Судалгааны өгөгдөл мэдээллийн шинж байдал, хамрах хүрээ өргөн байсантай холбоотой тус судалгаанд олон шатат, зорилтот түүврийн аргыг сонгосон болно. Төрийн аудитын байгууллагаас 2018, 2019 онд нийт 3,639 төлбөрийн акт, 5,758 албан шаардлага гаргаснаас гадна 16,607 зөвлөмж бүхий аудитын тайланг төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас цуглуулж, судалгаанд ашигласан байна.

Түлхүүр үгс: аудитын шийдвэр, ил тод байдал, өгөгдлийн шинжилгээ, албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмж

¹ Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын өгөгдөл, дүн шинжилгээ хариуцсан шинжээч

ОРШИЛ

Төрийн аудитын байгууллагын 2018-2022 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээнээс үзэхэд аудитын зөвлөмж, бусад шаардлагын хэрэгжилт өмнөх жилүүдээс жил дараалан буурч, нэг төрлийн асуудалд өгөх зөвлөмж, шийдэл давтагдах шинжтэй болж, үнэ цэнэ буурах хандлагатай болж байна. Энэ нь төрийн аудитын үйл ажиллагааны гол үр дүн болох зөвлөмж, шийдвэр (албан шаардлага, төлбөрийн акт) хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй болж, хүлээн зөвшөөрөгдөх түвшин нь буурч байгаагийн илрэл юм. Ийнхүү төрийн аудитын зөвлөмж, шаардлагын үнэ цэнэ буурч байгаа нь нэг талаас төрийн аудитын зөвлөмж, шаардлага өөрөө зохих шаардлагад нийцэхгүй байна уу, эсвэл тавьсан шаардлагыг хэрэглэгч (аудитад хамрагдсан байгууллага, албан тушаалтан) хүлээн авч хэрэгжүүлэхгүй байна уу гэдгээс хамаарна.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт тэдгээрт тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж, нөхцөл байдлыг тодорхойлж, энэ чиглэлээр баримтлах бодлого, арга зүйг боловсронгуй болгох, хөгжүүлэх, төлөвшүүлэх нь судалгааны тулгамдсан асуудал болж байна.

Төрийн аудитын байгууллагаас аудит хийх явцад илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж, шаардлага, түүний хэрэгжилт, үр дүн нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх асуудал тул энэхүү судалгаа нь цаг үеэ олсон, ач холбогдолтой бөгөөд цаашид үе шаттайгаар судалгааг үргэлжлүүлэх нь зүйтэй юм[1].

Төрийн аудитын байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд энэхүү судалгааны ажлын хүрээнд хийсэн шинжилгээ, дүгнэлт чухал нөлөөтэй юм. Төрийн аудитын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн шийдлүүд (албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмж) зохих шаардлагад нийцэж байгаа эсэх, тэдгээрийн чанар үр нөлөө, үр өгөөж ямар байгааг судалж, нөхцөл байдлыг хараат бусаар бодитой тодорхойлох боломж бүрдэнэ.

Энэ судалгааг төрийн аудитын байгууллагын шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар ерөнхий байдлаар үнэлж, дүгнэсэн бусад судалгаа, өгүүлэл, албан ёсны тайлан мэдээтэй харьцуулахад анх удаа 2 оны бодит мэдээллийн эх сурвалжийг иж бүрэн цуглуулж, түүнд үндэслэн дүн шинжилгээ хийснээрээ онцлогтой. Өөрөөр хэлбэл, энэхүү судалгааны ажил нь таамаг төдий биш, баримт нотолгоонд суурилан нөхцөл байдлыг бодитой тодорхойлсон гэж үзэх үндэстэй. Ингэснээр төрийн аудитын байгууллага Үндсэн хуулиар олгосон төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх чиг үүргээ нэр төртэй биелүүлэхээс гадна цаашдын бодлого, зорилтоо оновчтой тодорхойлох, аудитын чанар үр нөлөө нь дээшлэх боломж нэмэгдэхээс гадна улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө сайжрах юм.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, БОЛОВСРУУЛАЛТ

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Аудитын арга техник хөгжиж нарийсахын хэрээр нэр төрөл нь олшрох хандлага ажиглагдаж байгаа бөгөөд аудитыг хэзээ, хэн, юуг, ямар чиглэлээр, яаж шалгахаас хамааруулан ангилдаг байна. Аудитыг хэзээ хийхээс нь буюу аудитыг хийх цаг хугацаанаас хамаарч урьдчилсан ба дараах аудит гэж ангилж болно. Урьдчилсан аудит (pre-audit, priori audit, ex-ante) нь захиргааны болон санхүүгийн үйл ажиллагааг хийгдэхээс нь өмнө шалгадаг бол үйл ажиллагааны дараах аудит (post-audit, posteriori audit, ex-post) нь үйл ажиллагаа хийгдэж өнгөрсний дараа хийх аудит юм. Дотоод аудитын албыг байгууллагын дотор байгуулдаг бол хөндлөнгийн аудитын алба нь шалгагдаж байгаа байгууллагын зохион байгуулалтын бүтцэд ордоггүй.

Аудитын хамрах хүрээнээс хамааран нийцлийн (compliance audit), санхүүгийн (financial audit), гүйцэтгэлийн аудит (performance audit) гэж ангилна. Эдгээр 3 хэлбэр нийлээд иж бүрэн аудитын хүрээг бүрдүүлэх бөгөөд аливаа байгууллагын бүрэн дүр зургийг гаргаж чадна. Ямар чиглэлээр шалгах буюу шалгах асуудлын сэдэв, онцлогоос хамаарч аудитыг мэдээллийн технологийн аудит, байгаль орчны аудит, зохион байгуулалтын аудит, залилангийн аудит, орлогын аудит, улсын өрийн аудит, өмч хувьчлалын аудит, нийтийн аж ахуйн аудит гэх мэтчилэн төрөлжүүлж байна. Эдгээр аудитыг хийхэд нийцлийн аудит, санхүүгийн аудит, гүйцэтгэлийн аудитын арга зүйн аль тохиромжтойг нь, эсвэл хослуулан хэрэглэж болно. Аудитыг яаж хийх нь арга зүйн асуудал юм. Шалгах зүйлсийг нэг бүрчлэн буюу 100 хувь шалгах, эсвэл тэдгээрийн зарим хэсгийг төлөөлөл болгож түүвэрлэн шалгаад гарсан үр дүнг нийт олонлогт хамаатуулан тодорхойлох аргын аль алийг ашиглаж боломжтой.

ИНТОСАИ-н олон улсын аудитын ажлын хэсгийн гаргасан (ИНТОСАИ, 2005) номондоо олон улсын аудитын байгууллагууд үр дүнтэй аудит хийхийн тулд дараах зүйлд баталгаа өгөхүйц зарчмыг байх ёстой гэж дурджээ. Үүнд: Төрийн санхүүжилтээр аудит гүйцэтгэж буй аудитын дээд байгууллагууд ил тод, хариуцлага, сайн засаглалыг дэмжих ёстой бөгөөд хөндлөнгийн аудитор нь:

- Гүйцэтгэж буй аудитад бүрэн хараат бус байдлаар хандах;
- Олон улсын сайн туршлагад нийцсэн арга зүйгээр хангалттай нотолгоотой аудитыг гүйцэтгэдэг байх;
- Аудитыг хангалттай нөөцөөр гүйцэтгэдэг байх;
- Аудитын тайлан дахь үр дүнг засаглалын үйл ажиллагааг авч үздэг парламентын гишүүний өмнө хүлээх үүрэг хариуцлагатай байх;
- Холбогдох мэргэжлийн болон ёс зүйн стандартуудад нийцүүлдэг байх;
- Нээлттэй, үнэн зөв, нэвт тунгалаг байх.

Аудитын холбогдох стандартын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудит нь гүйцэтгэлийн холбогдолтой мэдээлэл материаллаг хэмжээний буруу ташаа зүйл агуулсан эсэх талаар үндэслэлтэй баталгаа гаргаж өгнө. Үндэслэлтэй баталгаа нь гүйцэтгэлийн холбогдолтой мэдээлэлд материаллаг хэмжээний буруу ташаа зүйл байгаа эсэх талаар аудиторын дүгнэлт гаргахад шаардагдах нотлох зүйлийг цуглуулахад хамаарна. Ямар зүйлийг “үндэслэлтэй” гэх нь тухайн нөхцөл байдлаас

шалтгаалах бөгөөд тухайн нөхцөлд ямар нотлох зүйл цуглуулах буюу ямар дүгнэлт гаргах боломжтой гэдгээр тодорхойлогдох учиртай[4].

Олон улсад төрийн аудитын дээд байгууллагууд төрийн аудитын гарын авлага, арга зүйг тогтмол шинэчилж боловсронгуй болгож байдаг байна. Тухайлбал, АНУ, Их Британи, Норвеги, Австралийн аудитын газрууд гарын авлага, бодлого, горим журам болон дагалдах бусад зүйлсийг боловсруулсан байдлаараа тэргүүлж байдаг бөгөөд хоёр жил дутамд шинэчилж байдаг байна. Энэ нь тухайн төрийн аудитын байгууллагуудад судалгаа, хөгжлийн тусгайлсан төвүүдтэй ажиллаж байдагтай холбоотой байна.

Норвеги Улсын Ерөнхий аудиторын газрын дэмжлэгтэйгээр Швед Улсын Үндэсний аудитын газар ахлан хийсэн түншийн үнэлгээгээр гүйцэтгэлийн аудитын үйл явц, чанарын хяналтын талаар тайланд дурдсан байна. Судалгааны дүгнэлтэд “Бодлогын газар болон Гүйцэтгэлийн аудитын газрын хоорондын хамтын ажиллагаа нь цаашид сайжруулах шаардлагатай чиглэл мөн болно. Үүнийг нэг талаар стандарт болон гарын авлага боловсруулахад Гүйцэтгэлийн аудитын газарт илүү үүрэг хариуцлага ногдуулах замаар хийж болно. Өөр нэг арга зам нь гүйцэтгэлийн аудитын мэдлэг чадвар болон үйл ажиллагааг төлөвшүүлэхийн тулд гарын авлага боловсруулах үйл явцад, эсвэл холбогдох сэдвүүдээр сургалт, семинар зохион байгуулахад тус газрын ажилтнуудыг оролцуулдаг байх явдал юм” гэж дурдсан байна[7].

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Б.Батбаярын “Төрийн аудитын тогтолцоо, арга зүйн шинэчлэлийн зарим асуудал” сэдвээр бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлээр (МУИС-ийн Эдийн засгийн сургууль, 2009) судалгаа хийжээ. Энэ судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын төрийн аудитын тогтолцоо, арга зүйн шинэчлэлийн үндсэн асуудлуудыг судлан, нэгтгэн дүгнэж, цаашид боловсронгуй болгох арга замыг тодорхойлох байсан бөгөөд үүнийг дараах зорилтуудын үндсэн дээр судалжээ. Үүнд:

1. Аудит, түүний дотор төрийн аудитын мөн чанар, зориулалт, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төрийн аудитын онол, арга зүйн гол үндэслэлийг тайлбарлах;
2. Монгол Улсад шинэ тутам үүсэн хөгжиж буй төрийн аудитын тогтолцоо, эрх зүйн орчин, бүрэн эрх, хараат бус байдлын өнөөгийн түвшин, стандарт, арга зүйн хэрэгжилтийг олон улсын стандарт, жишиг, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, шаардлага, орчин үеийн хандлага, шилдэг туршлагатай харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх;
3. Монгол Улсын төрийн аудитын тогтолцоо, арга зүйг цаашид боловсронгуй болгож, үр нөлөөг нь дээшлүүлэх арга замуудыг тодорхойлох зорилтууд тавьж судалжээ.

Мөн Монгол Улсын Үндэсний аудитын газар өөрийн гүйцэтгэлийн аудитын зохион байгуулалт болон үйл ажиллагаандаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасны дагуу Норвеги улсын ерөнхий аудиторын газрын дэмжлэгтэйгээр Швед Улсын Үндэсний аудитын газар ахлан түншийн үнэлгээг 2011 онд хийж, судалгаа авуулсан байна[3].

Түншийн үнэлгээний гол зорилго нь Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаа олон улсын сайн туршлагад нийцэж байгаа эсэхийг,

түүнчлэн тус байгууллага нь улс, нийгэмд ашиг тус өгч байгааг, өөрөөр хэлбэл төр, засгийн үйл ажиллагааны талаарх хараат бус, бодитой, найдвартай, ашиг тустай мэдээллээр Улсын Их Хурлыг хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэхэд оршиж байв.

Түншийн үнэлгээгээр дараах асуудлыг шалгаж үзсэн байна. Үүнд:

- Хараат бус байдал, чиг үүрэг
- Менежмент, мэдлэг чадвар, төлөвлөлт
- Аудитын үйл явц, чанарын хяналт, бусад байгууллагатай харилцах харилцаа
- УИХ-д үзүүлэх үйлчилгээ, нийгэмд өгч буй ашиг тус

Үндэсний аудитын газраас төрийн аудитыг үр дүнтэй гүйцэтгэж буй эсэхийг судалгааны ажлын түвшинд системтэй судалж, нэгтгэн дүгнэсэн ажил манай оронд одоогоор хараахан хийгдээгүй байна[6].

Төрийн аудитын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт тухайн нэг аудитын хувьд аудит хийгдсэн байгууллага, аудит хийсэн аудиторт нээлттэй ил байдаг боловч төрийн аудитын байгууллагын хэмжээнд эдгээр зөвлөмж, шийдвэрийн талаарх мэдээллийн сан байхгүйгээс нэгтгэсэн байдлаар судлах боломж хязгаарлагдмал байсан тул харьцангуй бага судлагдсан байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Төрийн аудитын байгууллага нь Төрийн аудитын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит гэсэн 3 төрлийн аудит хийж байна. Эдгээр аудит тус бүр өөр өөрийн бодлого, арга зүй, стандартад тулгуурлан хийгддэг бөгөөд аудитын үр дүнг аудитын тайлан хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэдэг. Аудитын тайланд удирдлагад зориулсан мэдээлэл багтах бөгөөд түүнд аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн аудитын зөвлөмжүүдийг бэлтгэж, хүргүүлдэг. Энэ нь төрийн аудитын гол үр дүн буюу шийдвэр юм. Харин аудитын явцад хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй, холбогдох хууль тогтоомж зөрчсөн, санхүүгийн бодит хохирол учруулсан нь баримтаар нотлогдвол төрийн аудитын байгууллага албан шаардлага өгөхөөс гадна хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоодог. Төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн талаарх 2018, 2019 оны зарим статистик мэдээг дараах байдлаар нэгтгэн үзүүлэв[1].


№	Үзүүлэлт	2018 он		2019 он	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тогтоосон төлбөрийн акт	1955	57,413.7	1687	19,255.9
1.1	Биелэлт	1476	21,519.2	1253	13,167.5
1.2	Биелэлт хувиар	75.5%	37.5%	74.3%	68.4%
2	Өгсөн албан шаардлага	2871	2,202,706.0	2897	1,993,888.0
2.1	Биелэлт	2076	433,979.3	2379	777,012.3
2.2	Биелэлт хувиар	72.3%	19.7%	82.1%	39.0%
3	Өгсөн зөвлөмж	9083		7524	5,167,076.1
3.1	Биелэлт	7368		6181	710,641.5
3.2	Биелэлт хувиар	81.1%		82.2%	13.8%

Хүснэгт 1. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн зарим статистик

Энэхүү статистик мэдээлэлд тулгуурлан 2018, 2019 онд Төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэж үзвэл 77.9 хувьтай байна. Төлбөрийн актын хэрэгжилтийн хувь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтнаас хамааралтай боловч эхлээд төрийн аудитын байгууллага буюу аудиторуд эдгээр захиргааны актыг зохих шаардлагад нийцсэн байдлаар бэлтгэж байна уу? гэдэг асуудлыг бодитой тодорхойлох нь чухал гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, төрийн аудитын байгууллагын зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, үр нөлөөгүй байгаа асуудлыг тодорхой зорилготой, харилцан уялдаатай, үе шаттайгаар судалж, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох нь зүйтэй гэдгийг төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан, статистик, бусад мэдээллээс харж болохоор байна.

Судалгааны ажлын зорилго, судлагдсан байдлын тойм зэрэг тулгуурлан судалгааны үзэл баримтлалын хүрээг дараах байдлаар томъёолов.



Диаграмм 1. Судалгааны үзэл баримтлалын хүрээний зураглал

А. Судалгааны эх олонлог, түүвэр

Судалгааны өгөгдөл мэдээллийн шинж байдал, хамрах хүрээ өргөн байсантай холбоотой тус судалгаанд олон шатат, зорилтот түүврийн аргыг сонгосон болно. Төрийн аудитын байгууллагаас 2018, 2019 онд нийт 3,639 төлбөрийн акт, 5,758 албан шаардлага гаргаснаас гадна 16,607 зөвлөмж бүхий аудитын тайланг төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас цуглуулж, судалгаанд ашигласан байна.

№	Шийдвэр, зөвлөмжийн төрөл	2018 он	2019 он	Нийт
1	Төлбөрийн акт	1,955	1,684	3,639
2	Албан шаардлага	2,871	2,887	5,758
3	Зөвлөмж	9,083	7,524	16,607
	Дүн	13,909	12,095	26,004

Хүснэгт 2. Төрийн аудитын байгууллагаас 2018, 2019 онд гаргасан нийт албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн талаарх мэдээллийн нэгтгэл (эх олонлог)

Судалгааны хүрээнд дээрх тооны мэдээллийг цахим хэлбэрээр авч судалгааны зориулалтаар дахин боловсруулалт хийж, үр дүнг нэгтгэсэн. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2018, 2019 онд аудитын үндсэн үр дүн, илрүүлэлт болох төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж аудитын 3 төрлөөр нийт 26,004 шийдвэр гарсан байна. Олон шатат, зорилтот түүврийг хийхийн тулд дараах шалгууруудыг ашиглан түүврийг хийсэн болно.

Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын хувьд:

1. Аудитын шийдвэр, үр дүн (төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж)
2. Байршлаар (Үндэсний аудитын газар (ҮАГ), аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар, нийт илрүүлэлтэд тухайн газрын эзлэх хувь)
3. 2018, 2019 оноор
4. Аудитын төрлөөр (гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит)
5. Биелэлтийн хувиар (хэрэгжсэн, хэрэгжээгүй)
6. Хуулийн дагуу хийгддэг аудит, ИТХ болон ҮАГ-ын санаачилгаар, бодлогоор хийгддэг аудитаас сонгох.

Санхүүгийн аудитын хувьд:

1. Төрийн аудитын газрын байршлаар (ҮАГ, ГАГ, НАГ, нийт илрүүлэлтэд тухайн газрын эзлэх хувь)
2. 2018, 2019 оноор
3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн нийт илрүүлэлтэд эзлэх хувиар
4. Төсвийн захирагчдаар
5. Биелэлтийн хувиар түүврийг хийв.

Үзүүлэлт	2018 он		2019 он		Нийт	
	Эх	Түүвэр	Эх	Түүвэр	Эх	Түүвэр
Төлбөрийн акт	1,955	97	1,671	83	3,639	180
Албан шаардлага	2,871	143	2,887	144	5,758	287
Зөвлөмж	9,083	454	7,524	376	16,607	830
Дүн	13,909	694	12,095	603	26,004	1,297

Хүснэгт 3. Төрийн аудитын байгууллагын аудитын шийдвэр, зөвлөмжийн үндсэн илрүүлэлтийн төрөл, оноор, эх болон түүвэр олонлог, тоогоор

Нийт эх олонлогт төлбөрийн акт 14%, албан шаардлага 20.7%, зөвлөмж 65.3%-ийг тус тус эзэлж байгаа ба эх олонлогийн 5%-ийг судалгаанд хамруулж, түүврийн төлөөллийн алдааны магадлал 90% хувьтай байна гэж тооцоолон түүврийг дээрх хүснэгтэд тусгагдсан байдлаар хийлээ.

№	Үзүүлэлт	Эх олонлог	Түүвэр олонлог	Хэрэгжээгүй зөвлөмжийн эх олонлог	Хэрэгжээгүй зөвлөмжийн түүвэр олонлог
1	Төлбөрийн акт	1,955	97	479	24
	Санхүүгийн аудит	1,571	79	290	15
	Гүйцэтгэлийн аудит	220	11	87	4
	Нийцлийн аудит	164	7	102	5
2	Албан шаардлага	2,871	143	795	40
	Санхүүгийн аудит	1,520	76	192	10
	Гүйцэтгэлийн аудит	506	25	207	10
	Нийцлийн аудит	845	42	396	20
3	Зөвлөмж	9,083	454	1,715	85
	Санхүүгийн аудит	6,943	347	505	25
	Гүйцэтгэлийн аудит	1,318	65	717	35
	Нийцлийн аудит	822	42	493	25
Дүн		13,909	694	2,989	149
	Санхүүгийн аудит	10,034	502	987	50

	Гүйцэтгэлийн аудит	2,044	101	1,011	49
	Нийцлийн аудит	1,831	91	991	50

Хүснэгт 4. Судалгааны түүврийн төлөөлөл, 2018 он, аудитын төрлөөр

Нийт сонгосон түүвэрт хамаарах 2018 онд төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн 72.3%-ийг санхүүгийн аудит, 14.6%-ийг гүйцэтгэлийн аудит, 13.1%-ийг нийцлийн аудитын шийдвэр зөвлөмж эзэлж байгааг дээрх хүснэгтээс харж болно.

№	Үзүүлэлт	Эх олонлог	Түүвэр олонлог
1	Төлбөрийн акт	1,671	83
	Санхүүгийн аудит	1,262	62
	Гүйцэтгэлийн аудит	213	11
	Нийцлийн аудит	196	10
2	Албан шаардлага	2,887	144
	Санхүүгийн аудит	1,854	93
	Гүйцэтгэлийн аудит	411	21
	Нийцлийн аудит	623	30
3	Зөвлөмж	7,524	376
	Санхүүгийн аудит	5,558	278
	Гүйцэтгэлийн аудит	1,100	55
	Нийцлийн аудит	866	43
Дүн		12,082	603
	Санхүүгийн аудит	8,674	433
	Гүйцэтгэлийн аудит	1,724	87
	Нийцлийн аудит	1,685	83

Хүснэгт 5. Судалгааны түүврийн төлөөлөл, 2019 он, аудитын төрлөөр

Түүвэрт хамруулсан 2019 онд төрийн аудитын байгууллагаас гаргасан нийт төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн 71.8%-ийг санхүүгийн аудит, 14.4%-ийг гүйцэтгэлийн аудит, 13.8%-ийг нийцлийн аудитын шийдвэр, зөвлөмж эзэлж байна.

Төрийн аудитын байгууллагын албан шаардлага, төлбөрийн актыг бүтэц, агуулгын хувьд дараах байдлаар ангилж болохоор байгаа бөгөөд ангилал тус бүрээр шалгуур үзүүлэлтийг тогтоож, үнэлэх нь зохимжтой гэж үзлээ. Үүнд:

- Тэмдэглэх хэсэг
- Захиргааны акт гаргах бодит нөхцөл байдал буюу зөрчил тодорхойлох хэсэг
- Хууль зүйн үндэслэл тодорхойлох хэсэг
- Шаардах / тогтоох хэсэг
- Баталгаажуулах хэсэг

Төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг үнэлэх шалгуурыг аль болох батлагдсан хууль, эрх зүйн акт, төрийн аудитын бодлого, арга зүйтэй уялдуулан сонгосон тул судалгааны үр дүн илүү бодитой байхаар тооцож, судалгааг хийсэн болно.

Шаардлага, шалгуурыг харгалзан түүвэрт хамруулсан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийг дараах үзүүлэлтээр үнэлэв. Үүнд:

1. Нийцсэн (С) - Тайлбар: Тухайн тохиолдлыг шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулахад 90-ээс дээш хувийн нийцэлтэй бол нийцсэн гэж үзнэ.
2. Хэсэгчлэн нийцсэн (РС) - Тайлбар: Тухайн тохиолдлыг шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулахад 50-90 хувийн нийцэлтэй бол хэсэгчлэн нийцсэн гэж үнэлнэ.
3. Нийцээгүй (NC) - Тайлбар: Тухайн тохиолдлыг шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулахад 50-аас доош хувийн нийцэлтэй бол нийцээгүй гэж үзэх боломжтой.

Цаашид эдгээр шалгуур, үнэлгээний үзүүлэлтийг боловсронгуй болгож, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг холбогдох шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлж, шалгах хуудас бий болгон төрийн аудитад нэвтрүүлэх нь ая холбогдолтой. Энэ нь аудиторунд аудит хийх явцад гаргасан үнэлэмж, шийдэл нь зохистой, оновчтой, үр нөлөөтэй байж чадах эсэхэд хяналт тавих жишиг, тулгуур болох юм[1].

СУДАЛЖ, БОЛОВСРУУЛСАН АРГА

Төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлагыг нэг багцалж, зөвлөмжийг тусгайлан нэг багц болгон шинжилгээ хийв. Аудитын зөвлөмж бэлтгэх нь төлбөрийн акт, албан шаардлага бэлтгэхээс харьцангуй онцлог ялгаатай бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжийн нийтлэг шинж чанарыг харгалзсан болно.

Төлбөрийн акт, албан шаардлагын тэмдэглэх болон баталгаажуулах хэсгийн үнэлгээг нэгтгэж үзвэл түүвэрт хамрагдсан нийт 467 төлбөрийн акт, албан шаардлагын 23 хувь буюу 109 тохиолдол шалгуур үзүүлэлтэд хагас нийцсэн, 3 тохиолдол шаардлагад нийцээгүй гэж үнэлэгдсэн байна.

Үнэлгээний үзүүлэлт	Тоо	Хувь	Шалгуурт хагас нийцсэн, нийцээгүй гэсэн үнэлгээ өгсөн нийтлэг үндэслэл, шалтгаан
Нийцсэн	355	76	
Хагас нийцсэн	109	23,3	• Үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай

			<ul style="list-style-type: none"> Захиргааны ерөнхий хуулийн 40.2.1, 40.2.2-т заасан шаардлагыг бүрэн хангаагүй Аудитын талаарх мэдээлэл хагас дутуу
Нийцээгүй	3	0,6	<ul style="list-style-type: none"> Цаад байгууллага нь хүлээн зөвшөөрөөгүй Хариуцагч байгууллага нь тодорхойгүй

Хүснэгт 6. Төлбөрийн акт, албан шаардлагын тэмдэглэх болон баталгаажуулах хэсэгт өгсөн үнэлгээний нэгтгэл


Үнэлгээний үзүүлэлт	Тоо	Хувь	Шалгуурт хагас нийцсэн, нийцээгүй гэсэн үнэлгээ өгсөн нийтлэг үндэслэл, шалтгаан
Нийцсэн	4	0,9	
Хагас нийцсэн	353	75,6	<ul style="list-style-type: none"> Үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай Зөрчлийг хэт ерөнхий ойлгомжгүй, тодорхойгүй томъёолсон Шалтгаан, үр дагаврыг дутуу тодорхойлсон
Нийцээгүй	110	23,6	<ul style="list-style-type: none"> Шалтгаан, үр дагаврыг тодорхойлох шаардлага байгаа боловч түүнийг төлбөрийн акт, албан шаардлагад огт тусгаагүй

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлагын шалтгаан, үр дагаварын хэсэгт өгсөн үнэлгээний нэгтгэл

Судалгааны явцад аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн шалтгаан, үр дагаврыг хэрхэн тодорхойлсон байдлыг үнэлэхэд дээрх нөхцөл байдал нийтлэг байсан бөгөөд тухайн асуудал нь үнэхээр материаллаг зөрчилтэй асуудал мөн үү? гэдэг нь түүний шалтгаан, үр дагавраас шууд хамаарах алдаа, зөрчил нийтлэг байсан. Энэ нь тухайн төлбөрийн акт, албан шаардлагын ач холбогдол, үр өгөөж буурч биелэлт хангалтгүй байх нэг шалтгаан болж байгааг харуулж байна.

Илрүүлсэн алдаа, зөрчлийн шинж байдлыг үнэлж, шийдвэр гаргахад түүний шалтгаан, үр дагаврыг бодитой, нотолгоотой тодорхойлох нь чухал бөгөөд шалтгаан, үр дагавар тодорхойгүй байх нь түүнийг зөрчилд тооцох эсэх, яаж шийдвэрлэхийг бодитой тогтоох боломжгүй болгож болох юм. Түүвэрт хамрагдсан 467 төлбөрийн акт, албан шаардлагаас алдаа, зөрчлийн шалтгаан, үр дагаврыг иж бүрэн тодорхой гаргаж тавьсан сайн үлгэр жишээ болох тохиолдол байхгүй байгаа тул шаардлага хангаагүй жишээ авах шаардлагагүй гэж үзлээ.

Аудиторууд зөрчлийг томъёолохдоо найруулга, үг үсгийн хувьд алдаагүй байгаа эсэх, товч тодорхой, ойлгомжтой байгаа эсэх, цаг үеэ олсон байх гэсэн шалгуурыг гол болгож “утга төгөлдөр” гэсэн үзүүлэлтийг үнэлсэн.



Диаграмм 1. Утга төгөлдөр, ойлгомжтой, тодорхой байх шалгуурт нийцсэн байдал

Төлбөрийн акт, албан шаардлагын нөхцөл байдал буюу зөрчил тодорхойлох үндсэн хэсэг нь ойлгомжгүй, тодорхойгүй байвал хариуцагч байгууллага түүнийг хүлээн авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болж, тухайн шийдвэрийн ач холбогдол, үр нөлөө буурахаас гадна хууль хяналтын байгууллагаар гомдол маргаан шийдвэрлүүлэх тохиолдолд өөрсдийн байр суурийг хамгаалж чадахгүй байх эрсдэлтэй юм. Иймд төлбөрийн акт, албан шаардлагад тухайн зөрчил гэж үзсэн нөхцөл байдлыг тодорхойлоход анхаарал хандуулж, цэг, таслал ч алдахгүй байх ёстой.

Судалгааны дүнгээс харахад түүвэрт хамрагдсан нийт 467 төлбөрийн акт, албан шаардлагын 285 буюу 61 хувь нь шаардлагад нийцэж байгаа ч 140 буюу 30 хувь нь шаардлагад хагас нийцсэн, 42 буюу 9 хувь нийцээгүй гэж үнэлэгдсэн.

Үнэлгээний үзүүлэлт	Тоо	Хувь	Шалгуурт хагас нийцсэн, нийцээгүй гэсэн үнэлгээ өгсөн нийтлэг үндэслэл, шалтгаан
Нийцсэн	242	51,8	
Хагас нийцсэн	180	38,5	<ul style="list-style-type: none">• Үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай• Зөрчлийг хэт ерөнхий ойлгомжгүй, тодорхойгүй томъёолсон• Аудитын талаарх мэдээлэл хагас дутуу
Нийцээгүй	45	9,6	<ul style="list-style-type: none">• Алдаа зөрчил гэж үзэх боломжгүй байдлаар томъёолсон

Хүснэгт 8. Шаардах / тогтоох хэсгийн утга төгөлдөр, ойлгомжтой, тодорхой байх шалгуурт өгсөн үнэлгээний нэгтгэл

Тавьсан шаардлагад хагас нийцсэн тохиолдлыг нарийвчлан судалж үзэхэд илрүүлсэн зөрчлийг хэт ерөнхий ойлгомжгүй, тодорхойгүй томъёолох байдал зонхилж байгаа бөгөөд үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай тохиолдол нийтлэг байна.

Төлбөрийн акт, албан шаардлагын “шаардах” хэсэгт илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар “юу” хийх вэ? гэдгийг тодорхойлох ёстой.

Түүвэрт хамрагдсан нийт 467 төлбөрийн акт, албан шаардлагын 30.4 хувь буюу 142 тохиолдол шаардлагад нийцсэн, 47.8 хувь буюу 223 тохиолдол шалгуур үзүүлэлтэд хагас нийцсэн, 21.8 хувь буюу 102 тохиолдол шаардлагад нийцээгүй гэж үнэлэгдсэн байна. Үнэлгээний дүнгээс үзэхэд нийт түүвэр олонлогоос “шаардлагад нийцээгүй” гэсэн дүгнэлт хамгийн олон авсан үзүүлэлтийн нэг болжээ.

Үнэлгээний үзүүлэлт	Тоо	Хувь	Шалгуурт хагас нийцсэн, нийцээгүй гэсэн үнэлгээ өгсөн нийтлэг үндэслэл, шалтгаан
Нийцсэн	142	30,4	
Хагас нийцсэн	223	47,8	<ul style="list-style-type: none"> • Үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай • Зөрчлийг арилгах арга зам тодорхойгүй • Алдаа, зөрлийн шалтгаан, нөхцөлийг дутуу тодорхойлсон • Шийдвэр гаргах батлагдсан үндэслэлээс өөр шийдвэр гаргасан • Нэг төрлийн зөрчлийг олон янзаар шийдвэрлэсэн
Нийцээгүй	102	21,8	<ul style="list-style-type: none"> • Бодит нөхцөл байдалд тохирсон оновчтой шийдэл гаргасан гэх үндэслэлгүй

Хүснэгт 9. Шаардах / тогтоох хэсгийн бодит нөхцөл байдалд тохирсон оновчтой шийдэл гаргасан байх шалгуурт өгсөн үнэлгээний нэгтгэл

Шаардлагад нийцээгүй гэсэн үнэлгээний хувь өндөр байгаа нь аудиторуд илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлынхаа засах залруулахыг бусдаас шаардах зөвлөх алхмыг чанартай сайн гүйцэтгэж чадахгүй байгааг харуулж байна. Өгсөн үнэлгээний нийтлэг үндэслэл, шалтгааныг дээрх хүснэгтэд харуулсан бөгөөд зарим тодорхой жишээг дараах хэсэгт харуулав.

Илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах шаардлага нь үндэслэл муутай байвал тухайн шийдвэрийн ач холбогдол, үр нөлөө буурах, хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бүрдэнэ. Ямар төрлийн алдаа, зөрчилд ямар шийдэл, шийдвэр гаргах талаар төрийн аудитын холбогдох журам, зааварт зохицуулсан заалт тусгасан байдаг боловч түүний хэрэгжилт хангалтгүй байгааг судалгааны дүн харуулж байна[7].

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас *тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар* нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно” гэж заасан байна. Гэтэл судалгааны явцад олон төрлийн зөрчилтэй асуудлыг нэг албан шаардлагаар өгдөг явдал нийтлэг байна. Тухайн илрүүлсэн зөрчлийн шинж байдлаас шалтгаалж, түүний зөрчилдсөн болон үндэслэл болгох эрх зүйн актын зүйл заалт, зөрчлийн шалтгаан, дагавар, шийдвэрлэх арга зам, хариуцах эзэн зэрэг харилцан адилгүй байдаг. Олон зөрчлийг нэг албан шаардлагаар шийдвэрлэх гэж оролдож байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцэхгүйн зэрэгцээ илэрсэн асуудлыг иж бүрэн шийдвэрлэж чадахгүй орхигдуулах, олон асуудал дунд зарим асуудал бүдгэрч, ач холбогдол нь буурах, хэрэгжилтийг тооцох боломж нөхцөл буурах эрсдэлтэй байна[10].

ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд төрийн аудитын байгууллагаас 2018, 2019 онд өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актаас түүвэрлэн авч сонгосон шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд 52.8 хувь буюу хоёр шийдвэрийн нэг нь шаардлагад бүрэн нийцээгүй байна. Энэхүү нөхцөл байдлыг сонгосон шалгуур үзүүлэлт бус бүрээр дор харуулав. Үүнд:

- Түүвэрт хамрагдсан төлбөрийн акт, албан шаардлагын тэмдэглэх болон баталгаажуулах хэсэг сонгосон шалгуурт дийлэнх нь нийцэж байгаа ч дөрвөн төлбөрийн акт, албан шаардлага тутмын нэг нь шалгуурт хэсэгчлэн болон бүрэн нийцээгүй байна. Энэ нь төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт нь үг, үсэг, утга найруулгын хувьд алдаатай, илрүүлсэн алдаа, зөрчлийг хэт ерөнхий ойлгомжгүй, тодорхойгүй томъёолсон зэргээс шалтгаалжээ.
- Захиргааны акт гаргах бодит нөхцөл байдал буюу зөрчил тодорхойлох хэсэгт өгсөн үнэлгээг нэгтгэж үзэхэд холбогдох шаардлагад хагас нийцсэн болон нийцээгүй гэсэн үнэлгээ 56.6 хувийг эзэлж байгаа нь төлбөрийн акт, албан шаардлага бэлтгэх энэ алхам төрийн аудитын байгууллагуудын хэмжээнд хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь утга төгөлдөр, ойлгомжтой, тодорхой байх, тухайн асуудал нь материаллаг хэмжээний чухал асуудал байх шалгуур хангагдаагүй бөгөөд алдаа, зөрчлийн шалтгаан, үр дагаврыг оновчтой тодорхойлоогүйтэй холбоотой байна.
- Төлбөрийн аудитын байгууллагаас өгч байгаа албан шаардлага, төлбөрийн акт нь захиргааны акт болохынхоо хувьд илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах шийдвэр гаргахдаа хууль зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлсон байх ёстой. Түүвэрт хамрагдсан тохиолдлын 88 хувь нь шаардлагад хагас нийцсэн болон нийцээгүй гэж үнэлэгдсэн нь тухайн асуудалтай зөрчилдөж байгаа болон шийдэл гаргахад үндэслэл болгосон хууль тогтоомжийн зүйл, заалтыг дутуу оруулсан, тохиромжтой биш хамааралгүй зүйл, заалт хэрэглэсэн, батлагдсан загварын дагуу зүйл, заалтыг дэлгэрэнгүй бичээгүй зэргээс шалтгаалжээ.
- Судалгаанд хамрагдсан төлбөрийн акт, албан шаардлагын шаардах болон тогтоох хэсгийг сонгосон шалгууртай харьцуулан үнэлэхэд 52.8 хувь нь хангалтгүй үнэлгээ авсан байна. Энэ нь төлбөрийн акт, албан шаардлагын шаардах болон тогтоох хэсгийг үг, үсэг, утга найруулгын алдаатай бичсэн, бодит нөхцөл байдалд тохирсон оновчтой шийдэл гаргаж чадаагүй, хэрэгжүүлэх ажил, арга зам нь тодорхойгүй, үр дүнг нь хэмжих боломжгүй, цаг үеэ олоогүй, оновчгүй шийдвэр гаргасан зэргээс шалтгаалсан байна.

САНАЛ

Төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэж, энэ үйл явцыг цахим системээр хянаж удирдах, удирдлагыг мэдээллээр хангах боломжтой болгох шаардлагатай байна. Энэ ажлыг судалгааны хүрээнд цуглуулж, боловсруулсан мэдээллийг улам баяжуулах, цар хүрээг нь өргөтгөх замаар хэрэгжүүлэх боломжтой юм.

Төрийн аудитын байгууллагын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулах, хариуцагчид хүргүүлэх болон түүний хэрэгжилтийн үйл явц, үр дүнг харуулсан хувийн хэргийг (хянах самбар) шийдвэр тус бүрд нээж хөтлөх үйл явцыг загварчилж, цахим хэлбэрт шилжүүлэхийг санал болгож байна. Энэ үйл явц нь шийдвэр гаргахаас эхлээд биелэлтийг тооцож баримтжуулан үр дүнг нь баталгаажуулж дуусах хүртэл хугацааг хамрах бөгөөд дараагийн тайлант хугацаанд тухайн байгууллагыг хариуцах аудиторт бэлэн мэдээлэл болохоос гадна өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитор юу хийх ёстойг чиглүүлэх боломжтой байх ёстой. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Аудитын үр өгөөжийг тооцож баталгаажуулах мэдээлэл болно.
- Цаг хугацаа хэмнэнэ.
- Цахим мэдээллийн сан бий болно
- Гарсан шийдвэр, түүний биелэлт, үр дүнд дүн шинжилгээ хийх боломжтой болно.
- Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад гаргасан шийдвэр, түүний явц, үр дүнд хяналт тавих боломжтой болно.
- Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр өгөөж, үр нөлөө нэмэгдэнэ.

Төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт, албан шаардлагыг ялгаж ангилах, нэгтгэхээс гадна мэдээллийн цахим сан үүсгэхэд шаардлага хангахуйц байдлаар дугаарлах аргачлал, загварыг боловсруулж, баталгаажуулах шаардлагатай.

Аудитын явцад нийтлэг илэрдэг алдаа, зөрчилтэй асуудлыг тухайн асуудалтай зөрчилдөж байгаа болон тухайн асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгох хууль эрх зүйн акттай нь уялдуулсан цахим мэдээллийн сан бий болгож, түүнийг аудиторруудад лавлагаа мэдээлэл байдлаар ашиглуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Батбаяр.Б. "Аудитын үр өгөөж, түүнийг сайжруулах арга замууд." УБ. (2010)
- [2] Батсайхан.Ж,. "Төрийн аудитын шийдвэр зөвлөмжийн хэрэгжилтэнд хийсэн шинжилгээ." (2020).
- [3] Батбаяр.Б. "Төрийн аудитын тогтолцоо, арга зүйн шинэчлэлийн зарим асуудал " УБ. (2009)
- [4] ИНТОСАИ., "Олон улсын аудитын байгууллагууд аудитыг чанарын өндөр түвшинд хийхдээ баримтлах зарчмууд" (2005).
- [5] Vaswani, Ashish, et al. "Attention is all you need." *arXiv preprint arXiv:1706.03762* (2017).
- [6] Ayodeji Ogunyemi,. "Монгол Улсын Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын үйл ажиллагаанд хийсэн Түншийн үнэлгээний тайлан." УБ (2018).
- [7] Коринне Таннер, Анна Вожтал. " ИНТОСАИ-н Аудитын дээд байгууллагын Гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлалыг ашиглан Монгол Улсын Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын үйл ажиллагаанд хийсэн Түншийн үнэлгээний тайлан." УБ (2016).
- [8] Төрийн аудитын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15357>
- [9] Захиргааны ерөнхий хууль, <https://legalinfo.mn/mn/detail/11259>
- [10] Төрийн аудитын байгууллага. (2022). Үйл ажиллагааны тайлан.
- [11] Төрийн аудитын байгууллага. (2021). Үйл ажиллагааны тайлан.
- [12] Төрийн аудитын байгууллагын 2018-2022 оны сургалт, хөгжлийн стратеги төлөвлөгөө. (2018).
- [13] Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө. (2018).
- [14] Үндэсний статистикийн хороо. (2017). Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх гарын авлага.
- [15] Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар. (2019). Мэдээллийн технологийн хөгжлийн чиг хандлага.
- [16] Цахим хөгжлийн яам. (2022). Цахим үндэстэн 2022-2027 дунд хугацааны зорилтод хөтөлбөр.